

**ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ
ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 217/A/III/ тогтоолоор 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталсан Хүний эрхийн түгээмэл тунхаглал¹-ын 19 дүгээр зүйлд "Хүн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэхүү эрхэнд үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрх чөлөө, үзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан аливаа арга замаар эрж сурвалжлах, хүлээж авах, түгээн дэлгэрүүлэх эрх чөлөө багтана." гэж, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны өдөр баталсан "Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт"-ын² 19 дүгээр зүйлд "1.Хүн бүр үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрхтэй. 2.Хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр, эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар, эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана. 3.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан эрхийг эдлэх нь онцгой үүрэг, хариуцлага оногдуулна. Тийм учраас түүнийг зарим талаар хязгаарлаж болох боловч тэр нь заавал хуулиар тогтоогдсон байх ёстой бөгөөд дараах шаардлагаас үүдэн гарсан байх ёстой:

а/ бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх;

б/ үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах."³ гэж заасан байна.

Эдгээр олон улсын хэм хэмжээг Монгол Улс хүлээн зөвшөөрч, дээрх баримт бичгүүдэд 1961 он болон 1974 онд нэгдэн орж, соёрхон баталсан байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16-д "итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй..." гэж заасан бөгөөд хэвлэн нийтлэх эрх нь үзэл бодлоо илэрхийлэх эрхийн нэг төрөл, түүнийг хэрэгжүүлэх хэлбэр, хүний зайлшгүй эдлэх үндсэн эрх юм.

Манай улс хүн бүр хэвлэн нийтлэх эрхтэй талаар Үндсэн хуульдаа заахын зэрэгцээ уг эрхийн хэрэгжилтийг хангах зорилгоор Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг 1998 онд баталсан бөгөөд өдгөө тус хуулийг шинэчлэн найруулах дараах хууль зүйн үндэслэл, практик шаардлага үүсээд байна.

¹ Universal Declaration of Human Rights (<https://www.un.org/en/about-us/universal-declaration-of-human-rights>),

² <https://www.ohchr.org/en/instruments-mechanisms/instruments/international-covenant-civil-and-political-rights>,

³ Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын конвенцийн 19 дүгээр зүйл, www.ohchr.org

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа"-ны Хүний эрхийг дээдэлсэн нийгэм бүтээх зорилгын хүрээнд 5.5.9-д "Хэвлэлийн эрх чөлөөг бүх талаар хангаж, ёс зүйтэй, мэргэшсэн сэтгүүл зүйг хөгжүүлнэ." гэж, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.1.Хүний эрх, эрх чөлөө бүлгийн "4.1.2.1.Хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт, хараат бус, бие даасан байдлыг хангах, тэдгээрийн редакцыг эздийн нөлөөллөөс гаргах, сэтгүүлчийн хэвлэн нийтлэх эрх чөлөө болон мэргэжлийн ёс зүйг баримтлан, хариуцлагатай ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлнэ." гэж, Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор баталсан Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийн Зорилт 3.4-т "Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчийг хамгаалах эрх зүйн орчныг бэхжүүлж, хариуцлагыг нэмэгдүүлнэ." гэж, 3.4.1.Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг шинэчлэн батлуулж, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын эрх, үүргийг тодорхой болгоно." гэж тус тус заасныг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Түүнчлэн, Монгол Улс хүний эрхийн төлөв байдлын талаарх үндэсний 3 дугаар илтгэлийг хэлэлцүүлсний мөрөөр НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн 2021 оны 3 дугаар сард хуралдсан 50 дугаар чуулганаас Монгол Улсын Засгийн газарт ирүүлсэн зөвлөмжид хэвлэн нийтлэх эрхийг баталгаажуулах шаардлагатай байгаа талаар зөвлөсөн байна.

1.2.Практик шаардлага

Монгол Улсын Их Хурлаас 1998 онд Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажуулах зорилгоор Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг баталж, мөн хуулиар төрөөс хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргах болон олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тогтоох, ийм төрлийн хяналт тавих байгууллага байгуулах, хяналтын үйл ажиллагааг санхүүжүүлэхийг хориглосон болно. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль нь хэвлэн нийтлэх эрхтэй холбоотой үндсэн агуулгыг зохицуулсан суурь хууль боловч өнгөрсөн хугацаанд хуулийн зохицуулалт хэт ерөнхий буюу хэвлэлийн эрх чөлөөг хамгаалахад хангалттай зохицуулалтыг агуулаагүй талаар дүгнэлт, зөвлөмжүүд гарсан байдаг.

Энэ нь Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг баталж байсан үетэй харьцуулахад мэдээлэл дамжуулах, хүлээн авах, хэвлэн нийтлэх боломж, хүрээ, хэлбэр улам бүр өргөжин, цаашид ч хувьсан өөрчлөгдөж байгаа тул цаг үеийн шаардлагад нийцүүлэн Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд илүү нарийвчилсан зохицуулалт тусгах замаар хэвлэн нийтлэх эрхийг нэг мөр баталгаажуулах доорх шаардлага тулгарч байна.

1.Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд хэвлэл мэдээлэл, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн мэдээллийн агуулгын хяналт буюу цензур, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтан зэрэг нэр томъёоны тайлбар байхгүй байгаа нь хууль хэрэглэх субъектүүдэд үүнийг хэрхэн ойлгох талаар нэгдсэн байр суурьгүй болгож, хууль хэрэглээний хувьд хүндрэлтэй асуудал үүсгэж байна. Тухайлбал, Улсын дээд шүүхээс гаргасан тогтоолуудад "хэвлэл, мэдээллийн хэрэгсэл"⁴, "олон

⁴ Улсын дээд шүүхийн 2000 оны Дампуурлын тухай Монгол Улсын хуулийн зарим зүйл, хэсэг,

нийтийн мэдээллийн хэрэгсэл” гэдгийг өөр өөрөөр тайлбарласан бол Зар сурталчилгааны тухай хуулийн 3.1.5-д “мэдээлэх хэрэгсэл” гэж телевиз, радио, холбооны шугам сүлжээ, компьютерын сүлжээ, тусгай программ, хэвлэл болон бусад арга хэрэгслийг ойлгохоор заажээ.⁵ Техник технологи хурдацтай хувьсан өөрчлөгдөж байгаа орчин цагт хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэдгийг уламжлалт байдлаар зөвхөн телевиз, радио, сонин, сэтгүүл зэргээр ойлгох нь оновчгүй бөгөөд зарим шинэ төрлийн хэвлэл мэдээллийн байгууллагыг хүлээн зөвшөөрч, хуульд тусгах, энэ салбарт тайлбар шаардлагатай байгаа бусад нэр томьёо, ойлголтуудыг тодорхойлох нь зүйтэй байна.

2.Хэвлэн нийтлэх эрх нь мөн чанараараа хоёр талтай буюу нэг талаас ямар нэг нөлөөлөл, дарамт, шахалтгүйгээр үзэл бодлоо чөлөөтэй хэвлэн нийтэлдэг байх, нөгөө талаас ийнхүү хэвлэн нийтлэх эрхээ хэрэгжүүлэх явцдаа бусдын нэр төр, нийгмийн ёс суртахууныг гутаахгүй, үндэсний аюулгүй байдалд сөрөг үр дагавар учруулахгүй байх гэсэн хүрээ хязгаарын дотор хэрэгжих зарчимтай юм. Хэвлэн нийтлэх эрхийн энэ чанарыг хүний эрхийн гэрээ, конвенц, улс орнууд нийтээрээ хүлээн зөвшөөрч, хууль тогтоомждоо баталгаажуулахдаа “хэвлэн нийлэх эрхтэй” гэх ойлголтын дор бусдын эрхийг зөрчихгүй байх үүднээс бусдын нэр төр, нийгмийн ёс суртахуун, үндэсний аюулгүй байдлаа хамгаалдаг болно. Иймд хуулийн төслийг энэхүү тэнцвэрийг хадгалах хүрээнд боловсруулах нь зүйтэй юм.

3.Хуулийн төслийг боловсруулахдаа одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиар тогтоосон үндсэн зарчмуудыг хэвээр хадгалахын зэрэгцээ, редакцын хараат бус байдлыг баталгаажуулах, редакцын мэргэжлийн үйл ажиллагаанд төр, эзэмшигч, ивээн тэтгэгч, бусад этгээд хөндлөнгөөс нөлөө үзүүлэхгүй байх зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай. Хэвлэл мэдээллийн байгууллагууд эдийн засгийн хараат байдлын улмаас бие даасан үйл ажиллагаа явуулж чадахгүйд хүрч хөрөнгө оруулагч, эздийнхээ ашиг сонирхлыг хамгаалах, томоохон бизнесийн бүлэглэлийн талын байр суурийг голлох зэрэг нөлөөнд автах эрсдэл бий болдог тул хэвлэл мэдээллийн байгууллага нь хуулиар хориглоогүй эдийн засгийн эх үүсвэртэй

заалтыг тайлбарлах тухай 1 дүгээр тогтоолын 3-т “Хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсгүүдэд заасан “хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ” гэдгийг шүүх хариуцагчийг төлбөрийн чадваргүй болсныг тогтоосноос хойш энэ хуульд заасан хугацааны дотор тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны хүрээг харгалзан төв, орон нутгийн өдөр тутмын сонин, хэвлэл, радио, телевиз буюу бусад аргаар зарлан мэдэгдэхийг ойлговол зохино.” гэжээ.

Улсын дээд шүүхийн 2000 оны “Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн зарим заалтыг тайлбарлах тухай” 151 дүгээр тогтоолын 4-т “Энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт заасан “Согтууруулах ундаа худалдах, борлуулах, хэрэглэх талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа хийхийг хориглоно” гэснийг бүх төрлийн сонин, сэтгүүл, радио, телевизээр болон зурагт ухуулах хуудсаар энэ хуулинд нэр заагдсан согтууруулах ундааг худалдан авах, хэрэглэхийг уриалсан, ухуулсан зар сурталчилгаа, рекламыг хамааруулан ойлгоно.”

Улсын лээл шүүхийн 2003 оны Шүүхийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай 01 дүгээр тогтоолын 13-т “Хуулийн 27.1-д заасан “...хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ” гэдгийг улс орон даяар тардаг өдөр тутмын хэвлэл, радио, телевизийн мэдээллийн хэрэгслийг ашиглахыг хэлнэ.”

⁵ Хууль зүй, дотоод хэргийн яам, Иргэдийн оролцоо төслийн захиалгаар хийлгэсэн «Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулга боловсруулах хэрэгцээ, шаардлагыг тандан судалсан судалгааны тайлан»-аас

байх, эзэмшлийн ил тод байдлыг хангах талаар зохицуулалт тусгах нь хэвлэл мэдээллийн байгууллагын хараат бус байдалд зайлшгүй нөлөөлөх хүчин зүйл юм.

Түүнчлэн, олон ургальч үзлийг бэхжүүлэх буюу олон янзын хэвлэл мэдээллийн байгууллага үйл ажиллагаагаа явуулах боломжийг хангах зорилгоор иргэдийн оролцоо, дуу хоолойг хамгийн ойрхоноос хүргэдэг ашгийн бус хамтын хэвлэл мэдээллийн хэрэгслийн талаар зохицуулалт тусгах нь хараат бус, олон ургальч хэвлэл мэдээллийн салбар оршин тогтнох үйл явцад эерэгээр нөлөөлөх юм.

4.Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрт мэдээллийн эрх чөлөө, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хангах талаар авах арга хэмжээний талаар тусгахдаа мэдээллийн эх сурвалжаа нууцлан хамгаалах сэтгүүлчийн эрх, үүргийг хуулиар баталгаажуулахаар заасан байдаг.⁶ Гэвч эх сурвалжаа хамгаалах, нууцлах эрх нь Монгол Улсын хуулиар /олон нийтийн радио телевизийнхээс бусад/⁷ сэтгүүлчдэд олгогдоогүй тул энэ эрх ихэнх сэтгүүлчдийн хувьд баталгаажгаагүй байна. Үүнээс шалтгаалаад шүүхийн шатанд болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үеэр сэтгүүлчийг эх сурвалжаа илчлэхийг албадан шаардах, ажил үүргээ гүйцэтгэхэд нь саад дарамт болох явдал байсаар байна. Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагад мэдээллийн эх сурвалжаа нууцлах эрх хуулиар олгоогүй тохиолдолд олон нийтийн эрх ашигтай холбоотой илчлэгдэхгүй байж болзошгүй, эмзэг мэдээллийг мэдэж байгаа эх сурвалж нь өөрийн аюулгүй байдал, ашиг сонирхолд санаа зовох үүднээс хэвлэл мэдээлэлд итгэл хүлээлгэн баримтаа өгөхгүй байх нь гарцаагүй юм.

Сэтгүүлчийн эх сурвалжаа нууцлах эрхийг баталгаажуулах нь мэдээлэгч бусад этгээдийн зүгээс хэрэгжүүлж болзошгүй аливаа арга хэмжээ авахаас айхгүйгээр сэтгүүлчийг мэдээллээр хангаснаар ил тод, хариуцлагатай байх соёлыг төлөвшүүлэх, авлига, эрх мэдлээ урвуулан ашиглах зэрэг хууль бус үйл ажиллагаатай холбоотой мэдээлэхгүй байж болзошгүй эмзэг мэдээллүүдийг сэтгүүлч хөтлөх, олон нийтэд хүргэх боломжийг олгодог буюу эцсийн үр дүнд нийгэмд бүхэлдээ үр шимийг хүртдэг байна. Иймд сэтгүүлчийн эх сурвалжаа нууцлах эрхийг хуулиар баталгаажуулж өгөх шаардлагатай байгаа болно.

5.Хэвлэн нийтлэх эрхээ хэрэгжүүлэхдээ бусдын нэр төр, нийгмийн ёс суртахуун, үндэсний аюулгүй байдалд хохирол учруулахгүй байх хүрээнд буюу үзэл бодлоо илэрхийлэх эрхэд тодорхой хязгаарлалт тогтоодог нь нийтлэг жишиг бөгөөд энэ чиглэлээр хэвлэл мэдээллийн байгууллага өөрийн нийтэлж, нэвтрүүлсэн мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцах, иргэд, хуулийн этгээдээс гаргасан гомдлыг редакц хүлээн авах, алдаатай мэдээлэл түгээсэн бол залруулга хийдэг байх, худал мэдээллийн талаарх ойлголтыг нарийвчлах хэрэгцээ байна.

Ёс зүйтэй сэтгүүл зүйг төлөвшүүлэхэд хэвлэл мэдээллийн салбарт өөрийн зохицуулалтын байгууллага нь дэлхийн 60-аад улсад 50 гаруй жил ажиллаж байгаа,⁸ олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сайн жишиг байна. Өөрийн зохицуулалтын байгууллага нь хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, олон нийтийн аль алинд ашиг тустай

⁶ УИХ-ын 2003 оны 41 дүгээр тогтоолын хавсралт “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”

⁷ Олон нийтийн радио, телевизийн тухай хууль, 2005 он.

34.2.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн ашиг сонирхол хөндөгдсөн гэж шүүх үзэж ил болгосноос бусад тохиолдолд олон нийтийн радио, телевизийн ажилтан мэдээллийн эрх сурвалжийг нууцлах эрхтэй.

⁸ Ш.Сүхбаатар. “Хүний эрх” сэтгүүл. Хүний эрхийн үндэсний комисс. 2019/01 дугаарын 5-11 дэх тал. “Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын онцлог, мөн чанар”.

бөгөөд ардчиллыг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдгээрээ өндөр ач холбогдолтой юм⁹.

Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт гэдэг нь хэвлэл мэдээллийн ёс зүйн хүрээнд сэтгүүл зүйн бүтээлийн чанарыг хэлэлцэх замаар хэвлэл мэдээллээр түгээсэн мэдээллийн улмаас хохирсон этгээдийн эрхийг хамгаалах тогтолцоо бөгөөд энэ нь төр, улс төр, бизнес, бусад хүчин зүйлсээс хараат бус, бие даасан, салбар нь өөрсдөө бий болгож, хүлээн зөвшөөрч, цаашид үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх сайн дурын бүтэц юм.

Иймд төрөөс хараат бус, бие даан үйл ажиллагаагаа явуулдаг, сэтгүүл зүйн үйл ажиллагаандаа баримтлах ёс зүйн дүрмийг батлах, ёс зүйн дүрэмтэй холбоотой иргэд, хуулийн этгээдийн гомдлыг шийдвэрлэх зэрэг үйл ажиллагаа явуулдаг хэвлэл мэдээллийн салбарын өөрийн зохицуулалтын байгууллагын эрх зүйн үндсийг тогтоох нь хариуцлагатай, ёс зүйтэй сэтгүүл зүй төлөвшихөд эерэг нөлөө үзүүлэх юм.

Хоёр.Хуулийн төслөөр зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийг түүний зорилго, хэвлэн нийтлэх эрх чөлөөтэй холбоотой нэр томъёог тайлбарласан нийтлэг үндэслэл, хэвлэл мэдээллийн хараат бус байдлын баталгаа, хэвлэл мэдээллийн байгууллагын хэлбэр, түүний ил тод байдал, хэвлэл мэдээллийн салбарт хэт төвлөрөлөөс сэргийлэх зохицуулалт, мэдээллийн эх сурвалжийг хамгаалах эрхийг баталгаажуулах, хэвлэл мэдээллийн салбарын өөрийн зохицуулалтын байгууллагын эрх зүйн үндэс зэргийг зохицуулах чиглэлээр боловсруулна.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хангах тухай ойлголт нь маш өргөн хүрээтэй бөгөөд хэвлэн нийтлэх эрх нь уг эрхийн бүрэлдэхүүн хэсэг буюу нэг хэлбэр нь юм. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх хэрэгжих буюу бүрэн хангагдаж байх явдал нь ардчилсан нийгмийн үнэт зүйл, ардчиллыг бат бөх оршин тогтнох үндсэн суурь болдог тул уг эрхийг хамгаалахын төлөө олон улсын нийгэмлэгүүд, ардчилсан улс орнууд олон төрлийн хууль тогтоомж, хэм хэмжээ батлан хэрэгжүүлдэг болно.

Манай улсад ч мөн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хангахтай холбоотой олон хууль тогтоомж үйлчилж байгаа тул Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслөөр хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтан, бие даан сэтгүүл зүйн үйл ажиллагаа явуулдаг этгээдийн нийгэмд нөлөө үзүүлж буй үйл явдал, бодлого, төлөвлөгөө, шийдвэр зэргийн талаар олон нийтийн эрх, ашиг сонирхлын төлөө нийгэмд мэдээлэл өгөхийн тулд үйл явдлыг ажиглах, тодорхойлон тайлбарлах, дүн шинжилгээ хийх, баримтжуулах зэрэг сэтгүүл зүйн үйл ажиллагаа явуулсны үндсэн дээр уг мэдээллийг цаасан, цахим, радио, телевизийн долгион, олон нийтийн мэдээллийн сүлжээг ашиглан хараат бус, ил тодоор хэвлэн нийтлэх үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулна.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх арга хэмжээний талаарх санал

Монгол Улсын нутаг дэвсгэр дээр аливаа хүн үг хэлэх, хэвлэн нийтлэх эрхээ баталгаатай хэрэгжүүлэх, олон нийт төр, эзэмшигч, бусад этгээдийн цензур буюу агуулгын хяналтгүй мэдээлэл олж авах эрх хангагдах, ингэснээр ардчиллын амин

⁹ Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгцээ, шаардлагыг тандан судалсан судалгааны тайлангаас

сүнс болсон олон ургальч үзэл, үзэл бодлын чөлөөт байдал бат бөх суурьтайгаар оршин тогтнох нөхцөл бүрдэх юм.

Хэвлэн нийтлэх эрх чөлөө, олон ургальч үзэл, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх хангагдсанаар нийгэмд ил тод байдал, эрх зүйт төр төлөвших үйл явцыг дэмжих, цаашлаад бусад эдийн засгийн эрхүүдийг хэрэгжүүлэх баталгаа болох суурь эрх хангагдах нөхцөл бүрэлдэх юм. Мөн хэвлэл мэдээллийг бусдын эрх ашгийг зөрчих, хувийн зорилгын төлөө ашиглахгүй байх, ёс зүй, мэргэжлийн өндөр мэдрэмжтэй салбарын хөгжилд хувь нэмэр оруулна.

Хэвлэн нийтлэх эрх, түүнтэй холбоотой бусад ойлголтуудыг нэг мөр ойлгох боломж бүрдэх, хэвлэн нийтлэх эрхийг өргөн хүрээнд тайлбарласнаар зөвхөн редакцтай хэвлэл мэдээллийн байгууллага бус олон нийтийн эрх ашгийн төлөө хэвлэн нийтлэх эрхээ хэрэгжүүлдэг бусад этгээдүүдийн эрхээ хэрэгжүүлэх боломж бүрдэх, хэвлэл мэдээллийн байгууллага мэргэжлийн үйл ажиллагааны хувьд хараат бусаар ажиллах, мэдээллийн эрх сурвалжаа хамгаалах эрхийг баталгаажуулснаар хууль бус байж болох үйлдлийг хэвлэл мэдээллээр дамжуулан илчлэх, хариуцлагатай, ёс зүйтэй сэтгүүл зүй хөгжих боломж бүрдэнэ.

Хэвлэл мэдээллийн хэт төвлөрөл бий болохоос сэргийлснээр олон ургальч үзэл оршин тогтнох орон зай нэмэгдэж, эзэмшигч ил тод, нээлттэй байснаар хэвлэл мэдээллийн хэрэгслийг улс төр, бизнесийн болон бусад хувийн зорилгоор ашиглахгүй болох юм.

Дөрөв. Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал:

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд нийцэж байгаа бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүдийг дагалдуулан боловсруулна.

-----ooOoo---